



НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН 2013 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАНД ХИЙСЭН СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын байгууллагын 2013 оны жилийн ажлын тайланд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албаны даргын 2014 оны 18 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг үнэлгээ хийлээ. Үнэлгээг хууль зүйн яамнаас боловсруулан гаргасан байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлалын дагуу холимог үнэлгээний хэлбэрийг сонгон гүйцэтгэсэн болно. Үнэлгээний ажилд НДҮЗ, НДЕГ-ын 2013 оны ажлын тайлан, Ерөнхий менежерийн үр дүнгийн гэрээний биелэлт, НДҮЗ-ийн тогтоол, НДЕГ-ын даргын тушаал болон холбогдох бусад баримтуудыг ашиглалаа. Монгол улсын төрөөс нийгмийн даатгалын талаар баримталж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилт, даатгуулагч иргэдийнхээ нийгмийн баталгааг хангахад чиглэсэн стратеги зорилтуудын хүрээнд 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө 24 арга хэмжээ, 142 ажил, 7 тусгай арга хэмжээ, 9 ажил нийт 31 арга хэмжээ, 151 ажил төлөвлөж, төсвийн ерөнхийлөн захирагчтай төсвийн шууд захирагчийн хийсэн үр дүнгийн гэрээний биелэлтээ 97.8 хувьтайгаар дүгнүүлсэн байна.

Нэг. Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн бодлогын болон үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар тогтвортой хөгжлийг хангах зорилтын хүрээнд:

Бүтэц зохион байгуулалт, чиг үүргийн талаар

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 30 дугаар тогтоолоор УНДЕГ-ын бүтцийг Ерөнхий газрын дарга, тэргүүн дэд дарга, хоёр дэд дарга, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийн газар, Төлөвлөлт, санхүү бүртгэлийн газар, (БНСУ дахь Нийгмийн даатгалын үйлчилгээний алба), Хяналт, шинжилгээ, үнэлгээний газар, Тамгын газар, (Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах хэлтэс, Өмчийн харилцааны хэлтэс), Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, УНДЕГ-ын дэргэд Эрүүл мэндийн даатгалын газар (Хяналт шалгалтын хэлтэс, Бодлого төлөвлөлтийн хэлтэс, Тусламж үйлчилгээний чанарын хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс), Мэдээллийн технологийн төв гэсэн нэгжүүдтэй байхаар



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

шинэчлэн баталсан байна. Одоогоор дээрх бүтцийн дагуу 152 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Бүтцэд Хяналт шинжилгээ үнэлгээний газар байгаа боловч чиг үүрэг нь хяналтаа давамгайлсан байна. Тус газарт үнэлгээ хариуцсан 1 мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд 2013 оны ажлын тайлан, болон нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаанд үнэлгээ хийгдээгүй байна.

УНДЕГ-ын даргын 2012 оны А/391 дугаар тушаалаар аймаг, дүүрэг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтэс, газрын бүтэц, орон тоо болон хүн ам олноор суурьшсан зарим аймаг дүүргүүдийн орон тоог тогтооход баримтлах нормативыг баталсан байна.

Нийслэлийн нийгмийн даатгалын газар нь дарга, дэд дарга, Тамгын хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Хяналт шалгалтын хэлтэс гэсэн бүтэцтэй, 21 ажилтантай, аймгийн нийгмийн даатгалын хэлтсүүд нь дарга, Нийгмийн даатгалын үйлчилгээний алба, Санхүү бүртгэл, орлого бүрдүүлэлт, хяналтын алба, Эрүүл мэндийн даатгалын алба гэсэн бүтэцтэй, нийт 923 ажилтантай, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд нь дарга, Нийгмийн даатгалын үйлчилгээний алба, Санхүү бүртгэлийн алба, Орлого бүрдүүлэлт, шимтгэлийн алба, Хяналт мониторингийн алба гэсэн бүтэцтэй, 405 ажилтантай тус тус ажилласан байна. 2013 онд Нийгмийн даатгалын системийн хэмжээнд нийтдээ 1455 үүнээс 116 гэрээт ажилтан ажилласан байна.

Сүүлийн 5 жилээр тооцож үзэхэд дундажаар даатгуулагчийн тоо 20.8 хувь , сайн дурын даатгуулагчдын тоо 286.6 хувиар тус тус өсөж, нийгмийн даатгалын байгууллагын ачаалал 2-3 дахин нэмэгдсэн бол ажиллагчдын тоо дундажаар 15.8 хувиар өссөн байна. Тухайлбал 2013 онд “Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хууль хэрэгжсэнээр 496,9 мянган хүний материалыг хүлээн авч, 421,8 хүний материалыг баталгаажуулан тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцсон байна. Хууль хэрэгжиж эхэлсэнээр сайн дураар даатгуулагчдын тоо 46,9 мянгаар өссөн нь аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдийн ажлын ачаалал эрс нэмэгдэж, орон тоо хүрэлцэхгүй болоход нөлөөлсөн байна.

Хүний нөөцийн талаар

Нийгмийн даатгалын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнийг нийт төв орон нутгийн байгууллагуудын төлөөлөлийг оролцуулан тэдэнд байгууллагын хөгжлийг



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

тодорхойлох, бүтээлч, чадварлаг, найрсаг хамт олон бүрдүүлэх онолын болон практик чадварыг суулгах зорилгоор 2013 оны 03 дугаар сарын 4, 5-ны өдрүүдэд зохион байгуулж, зөвлөгөөнөөр салбарын ололт амжилт, цаашдын зорилго зорилтоо тодорхойлж, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл, үйл ажиллагааны реформын талаар голчлон хэлэлцэж, 2012 оны ажлаа дүгнэн салбарын шилдэг байгууллага, шилдэг менежерүүдээ тодруулсан байна. Энэ зөвлөгөөнийг төв орон нутгийн бүх байгууллагын удирдлагыг оролцуулан өргөн хүрээнд зохион байгуулсанаараа шинэлэг болсон байна. Аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтэс, газруудын 2012 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж, I байрт Дорнод, II байрт Завхан, III байрт Хөвсгөл аймгийн НДХ-ийг тус тус шалгаруулан шагнаж урамшуулсан байна. Мөн аймаг, нийслэлийн хэлтэс, газрын дарга нарын үр дүнгийн гэрээг дүгнэж Дорнод аймгийн НДХ-ийн дарга Г.Саран, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дарга Э.Эрдэнэтуул нар “Нийгмийн даатгалын байгууллагын шилдэг менежер”-ээр шалгарч “Хүндэт өргөмжлөл”, 1 сарын үндсэн цалингаар тус тус шагнагдсан байна.

Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэх талаар

Салбарын нийт ажилтнуудын 1339 нь Монгол улсын төрийн албаны тухай хуулийн дагуу төрийн албаны шалгалт өгч, тангараг өргөсөн албан хаагчид бөгөөд төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээгээр цалинжин ажилладаг байна. Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс батлагдсан “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудад орон сууцны мөнгө тэтгэлэг олгох тухай” журмын дагуу төв, орон нутгийн 17 байгууллагын 57 ажилтанд мөнгөн тэтгэлэг, тэтгэвэрт гарсан 3 ажилтанд 66,9 сая төгрөгийн тэтгэмж, 17 ажилтанд 6,3 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, 1 ажилтанд 1,6 сая төгрөгийн эмчилгээний зардлыг тус тус олгосон нь ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэх талаар харьцангуй сайн ажилласан байна. Салбарын хэмжээнд 3 албан хаагчийг Алтан гадас одонгоор , 63 албан хаагчийг “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр, 30 албан хаагчийг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны “Жуух” бичгээр, 75 албан хаагчийг “Нийгмийн даатгалын хүндэт ажилтан” цол тэмдгээр, 69 албан хаагчийг Нийгмийн даатгалын “Хүндэт жуух” бичгээр тус тус шагнаж урамшуулсан байна

Сургалт, мэдээлэл, олон нийтийн харилцааг тогтмолжуулах чиглэлээр



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Салбарын хэмжээнд зохион байгуулах сургалтын хэрэгцээг тодорхойлох зорилгоор газрын нийт газар, хэлтсүүд болон нийгмийн даатгалын төв орон нутгийн хэлтсийн ажилтнуудыг хамруулсан санал, судалгаа авч сургалтын төлөвлөгөө боловсруулан ажилласан байна.

Тайлант хугацаанд “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”-ийг хэрэгжүүлэх, Нийгмийн даатгалын тухай багц хуулиудад орсон нэмэлт өөрчлөлтийг нэгдсэн ойлголттойгоор хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх, даатгалын хамралтыг өргөжүүлэх, орлогын бүрдүүлэлтийг сайжруулах зорилгын хүрээнд 2 өдрийн ажлын байран дээрх сургалтыг 9, 10,11 дүгээр сард “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийн санхүүжилтээр, Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетинг хөгжүүлэх жил”-ийн хүрээнд нийгмийн даатгалын салбарын санхүүгийн ажилтнуудын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэх, ажлын байран дахь сургалтыг Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтарч, “Багийн ажил-Миний ажлаас” сэдэвт хүний нөөцийн менежментийн “Төлөвлөлт, төсөвлөлт” сэдэвт сургалт, ажилтан албан хаагчдын мэдлэг боловсрол, эерэг харилцаа хандлага, соёл, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор “Ханголомт ТББ” – тай хамтарсан 24 цагийн сургалтуудыг аймаг, дүүрэг, сумдын байцаагчдыг хамруулан тус тус зохион байгуулсан байна.

Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн Газрын санхүүжилтээр Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо болон Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс хамтран хэрэгжүүлж буй “Бичил даатгалын зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийн санхүүжилтээр “Даатгал-бидний амьдралд” сэдэвт сургалтыг Хөвсгөл, Увс, Дорнод, Дархан-Уул, Сэлэнгэ аймгуудын 26 сумдад зохион байгуулсан байна.

Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай” төслийн санхүүжилтээр 12 аймгийн 35 сумын бичил уурхайгаас гар аргаар олборлолт хийж буй 2136 иргэнд Нийгмийн даатгалын болон Эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомж, түүний хэрэгжилт, авч болох тусламж үйлчилгээний талаар мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан байна.

Хөдөлмөрийн гэрээгээр Солонгос улсад ажил хөдөлмөр эрхлэхээр явж буй иргэдэд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар 9 удаа сургалт зохион байгуулж, сургалтанд 1000 гаруй хүн хамрагдсан байна.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг иргэд, даатгуулагчдад сурталчилан таниулах, системийн хэмжээнд гарч буй хууль эрх зүйн өөрчлөлтийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цаг алдалгүй хүргэх зорилгоор нийтдээ 223 удаа хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй холбогдон ажилласан байна.

www.ndaatgal.mn вэб сайтын үндсэн цэсийг шинэчлэн, нэмэлт оруулах болон цаг үеийн мэдээллийг цаг хугацаанд нь оруулж мөн facebook, twitter, социал медиа сайтуудыг ашиглан гадаад оронд албан бусаар ажиллагчдыг нийгмийн даатгалд хамруулах чиглэлээр сурталчилгааг зохион байгуулан ажиллаж байна.

Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол улсын иргэд “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуульд цахим хэлбэрээр хамрагдах нөхцөлийг бий болгон www.ndaatgal.mn вэб сайтад баннер байрлуулан шууд бүртгэж байлаа.

Гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр

Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн үндэсний байгууллага, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Солонгосын үндэсний тэтгэврийн алба, Сингапурын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Германы ослын нийгмийн даатгалын газар, Дэлхийн зөн, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Малдов улсын Үндэсний эрүүл мэндийн даатгалын газар, Литва улсын Үндэсний эрүүл мэндийн даатгалын сан, Тони Блэрийн холбоо, Вьетнам улсын эрүүл мэндийн даатгалын газар, Oxford business group, БНКУ-ын Монгол улс дахь Элчин сайдын яам, БНСУ-ын Монгол улс дахь Элчин сайдын яам зэрэг гадны байгууллагуудын төлөөлөгчдийг хүлээн авч ажил хэргийн санал солилцож, уулзалт хийсэн байна. Ижил төстэй гадаадын 15 орны нийгмийн даатгалын байгууллагуудын талаарх судалгаа хийгдэж, хамтран ажиллах арга замыг бүсчилсэн байдлаар тодорхойлж шинээр Малдов улсын Үндэсний эрүүл мэндийн даатгалын байгууллага, Япон улсын Тэтгэврийн сан, Сингапурын хамтын ажиллагааны нийгэмлэг, ХБНГУ-ын Ослын нийгмийн даатгалын газруудтай хамтын ажиллагааг эхлүүлэхээр хэлэлцэн тохирсноос Германы ослын нийгмийн даатгалын газартай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж, хамтын ажиллагаагаа шинэ төвшинд ахиулж чадсан байна. Гадаадын болон Олон улсын байгууллагаас гадаад, дотоодод зохион байгуулах олон улсын сургалт, семинар, зөвлөгөөнд газрын ажилтнуудыг оролцуулах



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

удирдамж, хэтийн төлөвлөгөө боловсруулж, гадаад хэл дээрх мэдээ мэдээллүүдийг орчуулан, 28 албан хаагчдыг сургалт, семинар зөвлөгөөнд оролцуулсан байна.

Бүгд Найрамдах Унгар улстай нийгмийн даатгалтай холбоотой асуудлаар хүсэлт гаргасан иргэдийн мэдээлэлийг цахим хэлбэрээр харилцан солилцож байхаар тохиролцсон байна.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар хоорондын Нийгмийн хамгааллын хэлэлцээрийн төсөлд оруулах саналыг боловсруулсан байна.

БНСУ-д нийгмийн даатгалын үйлчилгээний нэгжийг Нийгмийн халамж үйлчилгээний төв болгон өргөтгөж, тэнд ажиллаж амьдарч байгаа иргэддээ эх орондоо амьдарч байгаатай ижил хэмжээнд нийгмийн баталгаагаа хангуулах боломжийг бүрдүүлэн ажиллажээ.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явж буй 1300 даатгуулагчдад НД-ын хууль тогтоомжийг сурталчилж, тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээ бичиж олгосон байна. 2013 онд Солонгос дахь Нийгмийн халамж үйлчилгээний төв нь 1400.0 сая төгрөгийн шимтгэл төвлөрүүлэхээс 1431.4 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 102.2 хувиар биелүүлсэн байна.

БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас шимтгэлээ буцаан авахаар хүсэлт гаргасан 433 даатгуулагчийн нийт 514.3 сая төгрөгийн буцаан олголтын материалыг харьяа дүүрэг, аймгийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс хүлээн авч нэгтгэн сар бүр БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлсэн байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад гэрээний хугацаа дуусаад ирсэн 938 даатгуулагчид нийгмийн даатгалын дэвтэрт нь бичилт хийж баталгаажуулан, мэдээллийн баазад оруулсан байна.

Байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хугацаанд нь хууль тогтоомжийн хүрээнд шүүрхай шийдвэрлэх чиглэлээр

Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний системийн хэмжээнд мэдээллийн цахим сангаас иргэд даатгуулагч, ажил олгогчийн хүсэлтээр нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой лавлагааг түргэн шуурай хүргэх зорилгоор аймаг



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

(нийслэл), дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд ndlab програмд нэвтрэх эрхийг олголоо.

Нийгмийн даатгалын цахим сангаас мэдээлэл авахыг хүссэн 4358 иргэн, 1671 ажил олгогч, ОХУ, БНКУ, Казакстан, АНУ, БНСУ, Австралийн элчин сайдын яамдуудад 1796 иргэний мэдээлэл лавлагааны үйлчилгээ үзүүлсэн байна. Нийгмийн даатгалын байгууллагад гаргасан өргөдөл гомдол, саналыг цахим хэлбэрт оруулан бүртгэж, шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж архив, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу зохион явуулсан байна. Тус газарт байгууллага, иргэдээс ирсэн нийт 1342 албан бичиг, 680 өргөдөл, гомдлыг бүртгэн шийдвэрлэлтэнд хяналт тавин, 1249 албан бичгийн хариу өгч, 2237 албан бичиг явуулсан байна.

. Шинэчлэлийн Засгийн газраас ажиллуулж буй “11-11 Төв”-д нийгмийн даатгалын байгууллагатай холбогдолтой ирсэн 955 санал хүсэлтийг харъяалах газарт хуваарилан шийдвэрлүүлж ,954 буюу 99,9 хувийн санал хүсэлтийн хариу өгч ажиллалаа. Ирсэн асуултын 49.2 хувь нь тэтгэвэр тэтгэмжтэй, 15 хувь нь ажилласан жил нөхөн тооцох тухай хуультай холбоотой, 7.4 хувь нь ЭМД-тай холбоотой, 12.1 хувь нь НДШ-ийн талаар, 3 хувь нь хуулинд өөрчлөлт оруулах санал, 5.7 хувь нь НДХ, ажилтнуудтай холбоотой, 7.6 хувь нь бусад асуудлаар хандсан байна.

Санал дүгнэлт

Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн бодлогын болон үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар тогтвортой хөгжлийг хангах зорилтын хүрээнд хийсэн ажлуудыг харахад нийгмийн даатгалын үйл ажиллагаагаа сурталчилах, даатгалын үйлчлэх цар хүрээг өргөтгөх, даатгуулагчдын санал гомдлыг барагдуулах, гадаад хамтын ажиллагаагаа өргөтгөх чиглэлд илүү анхаарал тавьж ажилласан байна. Мөн гадаад улс орнуудад ажиллаж амьдарч байгаа иргэддээ хүрч ажиллах , тэдний нийгмийн баталгааг хангах талаар идэвх санаачилга гарган ажилласан байна. БНСУ дахь нийгмийн даатгалын нэг цэгийн үйлчилгээний нэгжийг Нийгмийн халамж үйлчилгээний төв болгон өргөтгөж, тэнд ажиллаж амьдарч байгаа 30,0 мянга орчим иргэддээ нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах нөхцлийг бүрдүүлж өгсөн нь гадаадад амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийн төлөө хийсэн томоохон үр дүнтэй ажил болжээ.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Нийгмийн даатгалын байгууллагууд нь одоогийн бүтэц зохион байгуулалтаараа сайн ажиллаж, стратегийн зорилтууд, үйл ажиллагааны болон, орлогын төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн боловч цаашид анхаарах шаардлагатай асуудлууд байна.

Цаашид анхаарах асуудлууд:

-Бүтэцдээ хяналт үнэлгээний нэгжийг бий болгох, тайлант хугацаанд салбарын байгууллагууддаа үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж байх, үнэлгээний дүнг хэлэлцэж, ажилдаа тусгаж хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авах

-НДЕГ-ын даргын тушаалаар батлагдсан бүтэц орон тооны хязгаар, одоогийн мөрдөж байгаа нормативыг хууль эрх зүйн хүрээнд шинэчлэн боловсруулах

-Бүтэц орон тооны нормативыг шинэчлэхдээ аймаг, дүүргийн орон тоо, бүтэц зохион байгуулалтын сүүлийн 10 жилийн динамик судалгааг даатгуулагч, ажил олгогчийн тооны өсөлттэй уялдуулан гаргаж, судалгааны үр дүнг ашиглах

-Оны шилдэг байгууллага, ажилтан шалгаруулах журмыг боловсронгуй болгох, шилдэгээр шалгарсан байгууллага, ажилтны тэргүүн туршлага, оновчтой санал санаачилга, ажлын ололт амжилтыг бусад байгууллагуудад үлгэр жишээ болгон сурталчлах, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, багаар ажиллахыг дэмжих зэрэг ажлыг зохион байгуулах

-Шилдэг байгууллага ажилтанд олгож байгаа шагналыг өгөөжтэй, дараагийн ажил амжилтанд хөтлөх хөшүүрэг болгох, идэвхжүүлэх хэлбэрээр зохион байгуулах, боломжуудыг судалж хэргэжүүлэх /Жишээ нь гадаадын ижил төстэй байгууллагуудын туршлага судлах аялалыг зохион байгуулах, ажлын байрны нөхцлийг сайжруулах, нийгмийн асуудал шийдэхэд илүү квот өгөх гэх мэт /

Ажлын тайлангаас харахад сургалтыг салбарын ажилтан албан хаагчиддаа мэдээлэл, зөвлөмж өгөх, ажлын байранд нь мэргэшүүлэх, нөгөө талаас даатгалын үйл ажиллагаагааг сурталчилах, хамрах хүрээг өргөтгөх, даатгуулагчдад мэдээлэл өгөх, даатгалын ач холбогдлыг ойлгуулах гэсэн 2 чиглэлээр зохион байгуулж, нэлээд өргөн хүрээг хамарснаараа хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, даатгуулагчдын тоог өсгөх, даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд сайнаар нөлөөлсөн байна.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Салбарын хүний нөөцийг хөгжүүлэх нэгдсэн хөтөлбөр төлөвлөгөө байхгүй, ажилтнуудыг чадавхижуулах, илүү мэргэшүүлэх талаар идэвхгүй ажиллаж, мэдээлэл өгөх, зөвлөмж өгөх зорилготой богино хугацааны сургалтыг хэсэгчлэн зохион байгуулсан нь хангалтгүй байна.

Цаашид анхаарах асуудлууд:

- Шинээр ажилд орсон ажилтнуудад чиглүүлэх сургалтыг хийж байх
- Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, ажилтнуудыг чадавхижуулах чиглэлд гадаад дотоодын мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтуудад түлхүү хамруулах боломжийг судалж, зохион байгуулах

Хоёр. Нийгмийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг, хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд:

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр

Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд нь нийгмийн даатгалын үйл ажиллагаанд голчлон хамаарах 28 хууль, нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай олон улсын 4 хэлэлцээр, улсын их хурлын 7 тогтоол, засгийн газрын 18 тогтоол, хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2 тогтоол, нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 18 тогтоол, холбогдох яамдын 141 тушаал шийдвэр, монгол улсын дээд шүүхийн 7 тогтоол, НДЕГ-ын тушаал шийдвэр болон бусад эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар “Найдваргүй авлагыг данснаас хасах тухай”, “Нийгмийн даатгалын байгууллагын ажилтнуудад орон сууцны мөнгөн тэтгэлэг олгох тухай” журам батлах зэрэг асуудлаар 34 тогтоол гаргаж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. /Тогтоолын хэрэгжилтийг хүснэгтээр гаргаж тайлангийн ард хавсаргав./

Улсын Их Хурлаас 2012 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хууль болон Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/57 тоот тушаалаар баталсан “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

журам"-ын хэрэгжилтийг хангаж, 496546 иргэний ажилласан жилийг нөхөн тооцож, 421800 иргэний баталгаажуулалтыг олгосон байна.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд олон ажил хийгдсэн байна.

Тухайлбал:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний бүртгэлтэй холбоотой мэдээллийн бааз, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газраас иргэдийн бүртгэлтэй холбоотой мэдээллийн баазыг тус тус шилжүүлэн авах ажлыг зохион байгуулсан. Архивын ерөнхий газарт “шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн лавлагаа”-ны үнийн тарифын талаар санал хүргүүлж, А/16 дугаар тушаалаар 500 төгрөгөөр тогтоосон. Цагдаагийн ерөнхий газраас гэмт хэрэгт холбогдсон эсэх тухай лавлагааг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй олгуулах үүднээс ЦЕГ-ын даргын хамтарсан А/18/5 дугаар тушаалаар тухайн лавлагааг хоёр байгууллагын хооронд мэдээлэл солилцох байдлаар зохицуулалт хийсэн.

Гадаадад ажиллаж амьдарч буй Монгол Улсын иргэдийг нөхөн даатгалд хамруулах зорилгоор ГХЯ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж, цахим мэдүүлгийн загварыг боловсруулан www.ndaatgal.mn сайтад баннер хэлбэрээр линк байршуулсан. (<http://203.91.118.155/refund/>) Мөн энэ ажлыг зохион байгуулах чиглэлийг хэлтсүүдэд өгч, сурталчилгааны материал 4000 ширхэгийг ГХЯ-аар дамжуулан монгол иргэд олноор суурьшсан улсын өөрийн орны Элчин сайдын яам, ерөнхий консулын газарт хүргүүлсэн байна

Нийгмийн даатгалын үйлчилгээний 1289 лавлах утсыг автомат хариулагчтай болгож, тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгал, ЭХМК, эрүүл мэндийн даатгал, шимтгэл төлөлт, БНСУ-д төлсөн шимтгэлийг буцаан олголт, оператортой холбогдох гэсэн мэдээлэл бүхий үндсэн 8 цэстэй модулаар бэлдэж, бичлэг хийлгэн, “Ньютел” ХХК-тай гэрээ байгуулан, олон оролттой автомат хариулагчтай холбож, 2013 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн ашиглаж эхэлсэн байна. 1289-ийн ачаалал эрс нэмэгдсэнтэй холбогдуулан, лавлах үйлчилгээний цар хүрээ, хүртээмжийг иргэд даатгуулагчдын дунд илүү сайжруулах зорилгоор “Мобиком” ХХК-ийн лавлах 1199 утсыг үйлчилгээнд ашиглах чиглэлээр судалгааны ажил хийгдэж гэрээ байгуулан хамтран ажилласан байна.



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Үндэсний статистикийн хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын даргын 2010 оны 01/62, 226, 58 тоот хамтарсан тушаалаар баталсан засаг захиргааны нэгжийн кодыг үндэслэн даатгуулагчийн ажлын байрны байршлын код тогтоож, НДЕГ-ын А/376 дугаар тушаалаар баталгаажуулан ажиллаж байна.

Сүүлийн 5 жилийн байдлаар хүн амын амьжиргааны доод түвшин 1,5 дахин, өргөн хэрэглээний барааны үнэ 1,2-2,7 дахин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 1,3 дахин, нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэврийн болон бусад тэтгэмжийн хэмжээ 1,5-2,3 дахин тус тус нэмэгдсэнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 26 дугаар тогтоолоор Тэтгэмжийн даатгалын сангаас олгож буй оршуулгын тэтгэмжийн хэмжээг 620,0 мянган төгрөгөөр тогтоож, 2014 оны 1-р сарын 1-ээс эхлэн мөрдөж эхэлсэн байна.

БНМАУ-ын Тэтгэврийн хуулиар тэтгэвэр тогтоолгоод 1991-1997 оны хооронд тэтгэвэр авч байсан хугацааг ажилласан жилээр нөхөн тооцоход хамрагдах тэтгэвэр авагчдын судалгааг нэгтгэн, тэтгэвэр авч байсан хугацааг нөхөн тооцсоноор нэмж шаардагдах хөрөнгийн тооцоог гаргасан байна.

Байгууллагын үйл ажиллагааны стратеги зорилт болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэл зааврын дагуу Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах санал, “Нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлийн үндсэн чиглэл”-ийн төсөл, “Ажилгүйдлийн даатгалын сангийн хөрөнгийг зарцуулах журам” зэрэг 60 гаруй санал, журмын төсөл, судалгаа тооцооллын ажлыг хийж, холбогдох газруудад хүргүүлсэн байна.

Тус газраас 2013 оныг “Нийгмийн даатгалын үйлчилгээний маркетингийг хөгжүүлэх жил” болгон зарлаж, дараах ажлуудыг санаачлан хийсэн байна.

Үйлчилгээний маркетингийн талаар онолын мэдлэг олгох сургалт зохион байгуулсан байна.

Монголын Үндэсний Радиотой хамтран “Нийгмийн даатгалтай малчин” улсын уралдааныг нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, малчдыг нийгмийн даатгалд хамруулан, тэдний тэтгэвэр, тэтгэмж авах нөхцлийг бүрдүүлж, малчдын ирээдүйн нийгмийн баталгааг хангах зорилгоор сум, багийн засаг дарга, малчдын дунд зарлаж, эхний шатанд шалгарсан малчин, засаг дарга нарыг шагнаж урамшуулсан байна.



“Нийгмийн даатгалын байгууллагын танилцуулга”-ын хэвлэлийн эх загварыг англи хэл дээр орчуулан бэлтгэж, хэвлүүлсэн.

Нийгмийн даатгалын салбарын маркетингийн төлөвлөгөө боловсруулах зөвлөх үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг хуулийн дагуу зохион байгуулж, зөвлөх үйлчилгээний “Интерконсалтинг групп” ХХК шалгаруулан, гэрээ байгуулж нийгмийн даатгалын байгууллагын маркетингийн стратеги төлөвлөгөө боловсруулах ажлыг эхлүүлсэн байна.

“Нийгмийн даатгалын сумын байцаагчийн ажлын байрны нөхцөл сайжруулах” судалгааг анхан шатны нэгжүүдийн дунд хийж, эхний ээлжинд тохижуулах сумдын судалгааг, холбогдох зардлын тооцооны хамт боловсруулсан байна.

Нийгмийн даатгалын холбогдолтой цаг үеийн чухал мэдээ, мэдээллээр иргэд, даатгуулагчдыг хангах зорилгоор “Имэйл маркетинг”-ийн загварыг боловсруулан “Эм Би Ти” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль”, “Нийгмийн даатгалтай малчин”, “Нийгмийн даатгал бидний амьдралд” сэдэвт уралдааны болзол зэрэг мэдээллийг бэлтгэн сар бүр тодорхой хугацааны давтамжтайгаар нийтдээ 400,0 мянган хэрэглэгчийн хаягт цахим шуудангаар илгээж, мэдээлэл хүрсэн байдлыг гүйцэтгэгч байгууллагын ашигладаг программын тусламжтайгаар хянаж ажилласан байна .

Тэтгэврийн карт бий болгох ажлын хүрээнд тэтгэвэр авагч болон нийгмийн даатгалын ажилтнууд ашиглах боломжтой Нийгмийн даатгалын ерөнхий газар, Төрийн банкны хамтарсан нийгмийн даатгалын “Ко-брэнд” картын загварыг боловсруулсан байна.

Санал дүгнэлт

Тайлант хугацаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, даатгуулагч иргэдэд чирэгдэлгүй шуурхай үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, даатгалын ач холбогдлыг иргэдэд ойлгуулах, сурталчилах талаар олон шинэлэг ажлуудыг санаачлан зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн байна. Дээрх ажлууд нь нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох, даатгалын хамрах хүрээг өргөтгөх, даатгуулагч иргэдийн эрх ашгийг хамгаалахад тодорхой хувь нэмрээ оруулах чухал ач холбогдолтой санаачлагууд болжээ.



Ялангуяа “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажилласаны үр дүнд улсын хэмжээнд хуулийн хэрэгжилтэд 496.7 мянган иргэнийг хамруулж, тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох нөхцлийг бүрдүүлж өгсөнөөрөө тэдгээр иргэдийн тэтгэврийн хэмжээ нэмэгдэх, цаашдын амьдралын баталгааг хангахад оруулсан маш том хөрөнгө оруулалт болсон байна. Мөн энэ хуулийн хэрэгжилтийг амжилттай зохион байгуулснаар сайн дураар даатгалд хамрагдагсдын тоо 46,9 мянгаар өссөн эерэг үзүүлэлт гарсан байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээний лавлах - 1289 тусгай дугаарын утсыг автомат хариулагчийн горимд шилжүүлж, иргэдийн санал хүсэлтийг 1199 мэдээллийн төвөөр авах зохицуулалт хийж, тайлант хугацаанд нийтдээ 11809 иргэнд мэдээлэл хүргэсэн байна. Лавлах утсыг ажиллуулснаар иргэд, даатгуулагчдад өдөр бүр 24 цагийн турш нийгмийн даатгалын үйлчилгээний талаар үнэн зөв мэдээлэл хүргэх, тулгамдсан асуудлуудыг зүй зохистой шийдвэрлэхэд томоохон хувь нэмэр оруулж байна.

Цаашид анхаарах асуудлууд :

-Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлтийг хийх, нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, эрх зүйн орчныг бүрдүүлэх

-Тайланд хэд хэдэн судалгаа хийсэн талаар дурдсан боловч судалгааны үр дүн, судалгаанаас гарсан дүгнэлтийг хэрэгжүүлэх талаар тусгаагүй байна. Цаашид судалгааны үр дүнг тодорхой болгох, гарсан дүгнэлтийг ажил хэрэг болгох талаар анхаарч ажиллах

-Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар иргэдээс ирж буй санал гомдлыг цаг тухай бүрд нь барагдуулах

-Салбар хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар тодорхой ажлуудыг хийх Тухайлбал: Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газартай хамтран ажиллах, чиг үүргийн хуваарилалтыг зохицуулах



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Гурав. Нийгмийн даатгалын сангийн төлөвлөлт, орлого бүрдүүлэлт, тэтгэвэр тэтгэмж, төлбөрийг хугацаанд нь олгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах зорилтын хүрээнд :

2013 онд төв орон нутгийн нийгмийн даатгалын 34 байгууллагын 1455 ажилтан ажиллаж , 3012,7 мянган даатгуулагчаас 1018.8 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулан, орлогын төлөвлөгөөг 104.8 хувиар биелүүлж, давхардсан тоогоор 4340.7 мянган даатгуулагчид 1058.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, нөхөн олговор, эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүллээ.

Санхүүгийн тайлангийн үнэлгээ

Сангийн нийт өмч 939,9 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 30.1 хувь буюу 217,4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.

Санхүүгийн байдлыг өмнөх онтой харьцуулан харуулбал:

/тэрбум төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Эцсийн үлдэгдэл		/+/- өсөлт, /-/- бууралт	
	2012 он	2013 он	Дүн	Хувь
МӨНГӨН ХӨРӨНГӨ	413,9	820,0	+406,1	+98,1
БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	188,1	-	-188,1	
АВЛАГА	124,1	117,2	-7,0	-5,6
УРЬДЧИЛГАА	0,7	0,5	-0,2	-28,6
БАРАА МАТЕРИАЛ	1,9	1,8	-0,1	-5
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	728,7	939,5	+210,8	+28,9
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,7	17,3	+3,6	+26,3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	742,4	956,8	+214,4	+28,8
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,0	16,9	-3,1	-15,5
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	20,0	16,9	-3,1	-15,5
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	722,4	939,9	+217,4	+30,1
ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	742,4	956,8	+214,4	+28,8

Мөнгөн хөрөнгө

/ сая төгрөгөөр/

Мөнгөн хөрөнгө	Эцсийн үлдэгдэл		+/ өсөлт, /- бууралт		Эзлэх хувь	
	2012 он	2013 он	Дүн	Хувь	2012 он	2013 он
Касс	4,2	0,6	-3,6	-85,7		
Замд яваа	9,8	0	-9,8			
Хадгаламж	163000,0	245000,0	+82000	50,3	39,4	29,9
Харилцах	250925,8	575020,4	+324094,6	129,2	60,6	70,1
НИЙТ ДҮН	413939,8	820021,0	+406081,2	98,1	100,0	100,0

Дүгнэлт: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 820,0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 406,1 тэрбум төгрөгөөр буюу 98,1 хувиар нэмэгдэж, санхүүгийн чадвар эрс дээшилсэн байна.

Авлага

/ сая төгрөгөөр/

Авлага	Эцсийн үлдэгдэл		+/ өсөлт, /- бууралт		Эзлэх хувь	
	2012 он	2013 он	Дүн	Хувь	2012 он	2013 он
НДШ	19600,0	24440,2	+4840,2	24,7	15,8	20,9
Улсын төсөв	88336,3	82990,0	-5346,3	6	71,2	70,9
Хүү	3136,2	1167,9	-1968,3	62,8	2,5	1
Хувь хүн	89,0	96,3	+7,3	8,2	0,1	0,1
Бусад байгууллага	12922,6	8449,9	-4472,7	34,6	10,4	
НИЙТ ДҮН	124084,1	117144,3	-6939,8	5,6	100	100


Дүгнэлт: Авлага нийт дүнгээр урьд оноос 5,6 хувиар буурсан ч НДШ, хувь хүнээс авах авлага 8,2-24,7 хувиар нэмэгдсэн бөгөөд хуримтлагдсан авлагын хэмжээ 3.2 тэрбум байна. НДҮЗ-ийн 2013 оны 06 дугаар сарын 11-ны өдрийн 16 дугаар тогтоолоор 4.6 тэрбум төгрөгийн найдваргүй авлагыг хүчингүй болгосон байна.

Тайлант онд тоон үзүүлэлтээс харахад авлага 5,6 хувиар буурсан харагдаж байгаа байгаа боловч найдваргүй авлагын 4,6 тэрбум төгрөгийн авлагыг хасахаар 1,8 хувиар буурсан байна. Цаашид авлага бууруулах, нэмж авлага үүсгэхгүй байх талаар, тодорхой ажлуудыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулах

Даатгалын хамралт

Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд 3012,7 мянган иргэн даатгуулж, өмнөх оноос 11,8 хувиар даатгуулагчдын тоо өсчээ.

Бүтцээр нь харуулбал:




Дүгнэлт: Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллага 35,4 мянга болж, өмнөх оноос 16,3 хувь буюу 4,9 мянгаар, сайн дурын даатгуулагч 46.9 мянгаар нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл тооцсон хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого:


2013 онд шимтгэл ногдуулсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого өмнөх оноос 20 хувь буюу 0,83 тэрбум төгрөгөөр нэмэгдэв.

Графикаар харуулбал:

/тэрбум төгрөгөөр/



Дүгнэлт: Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого өссөн нь аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын тоо өссөнөөс шалтгаалсан байна. Графикаар харуулбал:



/тэрбум төгрөгөөр/

Төсвийн гүйцэтгэлийн үнэлгээ

Орлогын гүйцэтгэл

/тэрбум төгрөгөөр/

Нийгмийн даатгалын сан	2012 он	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Давсан	
		Орлого	Нийтэд эзлэх хувь	Орлого	Нийтэд эзлэх хувь	Дүн	Хувь
Тэтгэврийн	446,7	606,0	62,4	635,0	62,3	29,0	4,8
Тэтгэмжийн	32,5	68,9	7,1	67,3	6,6	-1,6	-2,3
ҮОМШӨ-ний	53,4	73,2	7,5	86,7	8,5	13,5	18,4
Ажилгүйдлийн	35,4	21,1	2,2	25,8	2,5	4,7	22,2
Эрүүл мэндийн	152,2	202,3	20,8	204,1	20,1	1,8	0,9
НИЙТ	720,2	971,5	100,0	1018,8	100	47,3	4,9

Дүгнэлт: НДШ-ийн орлого өмнөх оноос 298.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох хууль амжилттай хэрэгжсэн нь орлогын төлөвлөгөө давж биелэхэд голлох нөлөө үзүүлсэн байна.

Зарлагын гүйцэтгэл

Зарлагыг сан тус бүрээр харуулбал:

/тэрбум төгрөгөөр/

Нийгмийн даатгалын сан	2012 он	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Давсан	
		Зарлага	Нийтэд эзлэх хувь	Зарлага	Нийтэд эзлэх хувь	Дүн	Хувь
Тэтгэврийн	722.5	829.3	77.66	826.4	78.10	2.9	0.35
Тэтгэмжийн	42.6	57.5	5.38	58.7	5.55	-1.2	-2.09
ҮОМШӨ-ний	28.5	34.3	3.21	31.4	2.97	2.9	8.45
Ажилгүйдлийн	7.7	15.3	1.43	16.1	1.52	-0.8	-5.23
Эрүүл мэндийн	117.4	131.4	12.31	125.5	11.86	5.9	4.49
Нийт	918.7	1067.8	100.00	1058.1	100.00	9.7	0.91



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Дүгнэлт: Нийгмийн даатгалын 5 сангаас даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуулийн дагуу хугацаанд нь олгожээ.

Нийгмийн даатгалын 5 сангийн зарлагаас тэтгэмжийн даатгалын сан 2,09%, ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 5,23 хувиар тус тус төлөвлөгөөг хэтрүүлсэн, бусад 3 сан 0,35-8,45 хувиар хэмнэгдсэн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зарлага

Тэтгэвэр авагчийн тоо, зарцуулсан хөрөнгийг өмнөх он, төлөвлөгөөтэй харьцуулбал:

/мянган тэтгэвэр авагч, тэрбум төгрөгөөр/

Тэтгэврийн төрөл	2012 он	2013 он	өсөлт+, бууралт-		2013 он		өсөлт+, Бууралт-	
	Хүний тоо	Дүн	хувь	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Дүн	хувь	
Өндөр насны	210,9	217,7	+6,8	3,2	591,2	593,3	-2,1	3,5
Тахир дутуугийн	50,5	51,3	+0,8	1,6	101,9	98,9	3	2,9
Тэжээгчээ алдсаны	23,9	22,5	-1,4	5,8	48,5	45,7	2,8	5,8
Цэргийн	14,9	15,6	-0,7	4,7	71,2	72,6	-1,4	1,9
НИЙТ	300,1	307,1	7,0	2,3	812,8	810,5	2,3	0,3

Дүгнэлт: 2013 онд тэтгэврийн даатгалын сангаас өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй, тэжээгчээ алдсан 307.1 мянган иргэнд 810,5 тэрбум төгрөг зарцуулав.

Нийт тэтгэвэр авагчдын 44,1 хувь буюу 135,6 мянган иргэн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр авч байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага

Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийг харуулбал:

/мянган хүнээр, тэрбум төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Тэтгэмжийн төрөл	Хүний тоо				2013 он			
	2012 он	2013 он	өсөлт, бууралт	%	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	өсөлт, бууралт	%
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны	98,9	104,4	+5,5	5,6	10,6	10,2	0,4	3,7
Жирэмсний болон амаржсаны	38,5	45,7	+7,2	18,7	42,3	44,7	-2,4	5,7
Оршуулгын тэтгэмж	12,9	12,4	-0,5	3,9	4,5	3,7	0,8	17,7
НИЙТ	150,3	162,5	12,2	8,1	57,4	58,6	-1,2	2,1

Дүгнэлт: Тэтгэмжийн даатгалын сангаас 162,5 мянган даатгуулагчдад 58,7 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж олголоо. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага даатгуулагчийн дундаж цалингийн өсөлт, төрөлт нэмэгдсэнээс шалтгаалан 1,2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага

2013 онд тахир дутуугийн болон тэжээгчээ алдсан 6.5 мянган тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 26,9 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсан 1,0 мянган хүний тэтгэмжид 0,5 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон рашаан сувиллын зардалд 0,9 тэрбум төгрөгийг 4,6 мянган даатгуулагчдад, тахир дутуу болсон даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлд 0,8 тэрбум төгрөгийг тус тус уг сангаас санхүүжүүлсэн байна.

Зарлагыг өмнөх онтой харьцуулбал:

/мянган хүнээр, тэрбум төгрөгөөр/

Төрөл	Хүний тоо	2013 он
-------	-----------	---------

	2012 он	2013 он	Өсөлт, бууралт	%	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Өсөлт, бууралт	%
Тэтгэвэрт зарцуулсан хөрөнгө	6,7	6,5	-0,2	3	28,7	26,9	1,8	6,3
ХЧТА-ны тэтгэмж	0,8	1,0	+0,2	25	0,6	0,5	0,1	16,7
Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбоотой төлбөр, сувиллын зардал	4,5	4,6	-0,1	22,2	1,7	0,9	0,8	47,0
Тэтгэврийн даатгалын санд шилжүүлсэн шимтгэл					0,9	0,8	0,1	11,1
НИЙТ	12,0	12,1	0,1	0,8	31,9	29,1	2,8	8,7

Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага

/мянган хүнээр, сая төгрөгөөр/

	Хүний тоо	2013 он		өсөлт, бууралт	
	2013 он	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Дүн	%
Ажилгүйдлийн тэтгэмж	15,9	13383,5	14905,4	1521,9	11,4
Сургалтын төлбөр	0,01	43,8	0,05	-43,75	99,8



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

НИЙТ ДҮН	15,91	13427,3	14905,45	1478,15	11,0
----------	-------	---------	----------	---------	------

Дүгнэлт: 2013 онд ажилгүйдлийн тэтгэмжийг 1521,9 сая төгрөгөөр хэтрүүлсэн, сургалтын төлбөрийг 43,75 сая төгрөгөөр хэмнэсэн. Ажилгүйдлийн тэтгэмжийн өсөлт нь 2013 онд улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 42772 болж өссөнтэй холбоотой.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага

/мянган хүнээр, тэрбум төгрөгөөр/

Тусламж үйлчилгээ	Хүний тоо		Өсөлт, бууралт		2013 он		Өсөлт,бууралт	
	2012 он	2013 он	Дүн	Хувь	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Дүн	Хувь
Эмнэлэг, Сувилал	3364,7	2988,7	-376,0	11,2	114,3	111,0	3,3	2,9
Эмийн үнийн хөнгөлөлт	706,9	854,5	+147,6	20,9	12,1	9,7	2,4	19,8
НИЙТ ДҮН	4126,4	3843,2	-283,2	6,9	126,4	120,7	5,7	4,5

Дүгнэлт: Эрүүл мэндийн даатгалын сангаас 3843,2 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардалд нийт 120,7 тэрбум төгрөгийг зарцууллаа.

Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдаж төлбөр тусламж авсан хүний тоо урьд оноос 283,2 мянган хүнээр буурч, олгосон хөрөнгө 5,7 тэрбум төгрөгийг хэмнэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тэнцэл

Тэнцэлийг харуулбал:

/тэрбум төгрөгөөр/

Нийгмийн	Орлого	Зарлага	Зөрүү
----------	--------	---------	-------



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

даатгалын сан			
Тэтгэврийн	899,6	826,4	73,2
Тэтгэмжийн	67,3	58,7	8,6
ҮОМШӨ-ний	86,7	31,4	55,3
Ажилгүйдлийн	25,8	16,1	9,7
Эрүүл мэндийн	204,1	125,6	78,5
НИЙТ ДҮН	1283,5	1058,2	225,3

Дүгнэлт: Нийгмийн даатгалын сангууд нь тайлант онд орлогоороо зарлагаа нөхөж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өссөн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн дагуу эрх үүссэн даатгуулагчдын тэтгэмжийг тухайн сангийн оны эхний хуримтлагдсан үлдэгдлээс олгосон.

Нийгмийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө тэтгэвэр тогтоосон иргэдийн тэтгэврийг Засгийн газар хариуцах үүргийн дагуу тайлант онд 268,6 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд төвлөрүүлэхээс 264,6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.


Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын зардлын талаар

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд 23,8 тэрбум төгрөг зарцуулах төлөвлөгөөтэйгээс 23,3 тэрбум төгрөг зарцуулж 0.5 тэрбум төгрөг хэмнэсэн байна.

Урсгал зарлага

Нийгмийн даатгалын байгууллагын урсгал үйл ажиллагааны зардалд 18376,8 сая төгрөг зарцуулахаас 18042,4 сая төгрөгийг зарцуулсан.

Графикаар харуулбал:



Цалин хөлс болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг төлөвлөгөөтэй харьцуулбал:

/сая төгрөгөөр/

Зардал	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	Өсөлт+, бууралт-	
			Тоогоор	Хувиар
Үндсэн цалин	11270,5	11234,7	-35,8	0,32
Гэрээт ажлын цалин	543,8	522,8	-21,0	3,87
Нийгмийн даатгалын шимтгэл	1365,9	1332,3	-33,6	2,5
Унаа, хоолны хөнгөлөлт	602,8	551,5	-51,3	8,52
НИЙТ ДҮН	13783,0	13641,3	141,7	1,02

Нийгмийн даатгалын байгууллагын дүнгээр цалин болон нийгмийн даатгалын шимтгэлийн зардал урсгал зардлын 96%-ийг эзэлж, зардлын гүйцэтгэл нь 13641,3 сая төгрөгт хүрчээ.

Тогтмол зардлыг төлөвлөгөөтэй нь харьцуулбал:

/сая төгрөгөөр/



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Зардал	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	+/ өсөлт, -/ бууралт	
			Тоогоор	Хувиар
Гэрэл цахилгаан	115,9	102,3	-13,6	11,7
Түлш, халаалт	427,4	357,0	-70,4	16,5
Цэвэр, бохир ус	61,1	58,7	-2,4	3,9
Байрны түрээс	186,8	202,8	+16	8,5
НИЙТ ДҮН	791,2	720,8	-70,4	8,9

Түрээсийн зардал 16.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь Баянзүрх, Налайх дүүргийн барилгын ашиглалтын хугацаа дуусч, дахин ашиглах боломжгүй шийдвэр гарсантай холбоотой түрээсийн зардал өссөн.

Ажил олгогчоос олгох бусад тэтгэмжийн зардлыг төлөвлөгөөтэй нь харьцуулбал:

/сая төгрөгөөр/

Зардал	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	+/ өсөлт, -/ бууралт	
			Тоогоор	Хувиар
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	390,9	389,8	-1,1	0,3
Орон байраар хангах, орон сууцны дэмжлэг	350,0	350,0	-	-
Нэг удаагийн буцалтгүй тусламж	21,7	40,2	+18,5	85,3
Ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал	16,1	7,9	-8,2	50,9
Эмчилгээний төлбөр	15,9	4,3	-11,6	72,9
Шагнал урамшуулал	580,9	547,9	-33,0	56,8
Хуульд заасан үндэслэлээр олгох тэтгэмж	109,5	128,3	+18,8	17,2
НИЙТ ДҮН	1485,0	1468,4	16,6	1,1



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хөрөнгө оруулалт

Нийгмийн даатгалын байгууллагын батлагдсан бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний дагуу сангаас 5255,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлжээ.

Хөрөнгө оруулалтыг төлөвлөгөөтэй нь харьцуулбал:

/сая төгрөгөөр/

Зардал	Төлөвлөгөө	Зарцуулсан хөрөнгө	/+/- өсөлт, /-/- бууралт	
			Тоогоор	Хувиар
Барилга байгууламж, их засвар	4213,9	4101,1	-112,9	2,7
Тоног төхөөрөмж	521,8	515,7	-6,1	1,1
Тээврийн хэрэгсэл	340,0	332,8	-7,2	2,2
Тавилга, эд хогшил	307,2	306,3	-0,9	0,3
НИЙТ ДҮН	5383,0	5255,8	-127,2	2,3

2013 онд нийгмийн даатгалын байгууллага 1 төгрөгийн шимтгэлийн орлого олоход 0.02 төгрөгийн зардал гаргаж ажилласан байна.

Хүснэгт /тэрбум төгрөгөөр/

Он	Шимтгэлийн орлого	Урсгал болон хөрөнгө оруулалтын зардал	НД-ын шимтгэлийн орлогод зардлын эзлэх хувь	1 төгрөгийн зардлаар олж буй шимтгэлийн орлого
2010 оны IV улирал	404.1	9.6	2.4%	42.1
2011 оны IV улирал	565.1	11.9	2.1%	47.5
2012 оны IV улирал	798.8	14.5	1.8%	55.1
2013 оны IV улирал	1018,8	23.3	2,3%	43,7



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Нийгмийн даатгалын байгууллага шимтгэлийн орлогын 2.3 хувийг урсгал болон хөрөнгө оруулалтын зардалд зарцуулжээ. Өөрөөр хэлбэл 1 төгрөгийн зардлаар 43,7 төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлж байна.

Тав. Эрүүл мэндийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, даатгуулагчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт хяналт тавих зорилтын хүрээнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газар нь 2013 онд иргэдийг эрүүл мэндийн даатгалд даатгаж, сангийн орлогыг бүрдүүлэн, даатгуулагчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээг худалдан авдаг даатгуулагч төвтэй, нийгмийн хариуцлага бүхий менежментийг хэрэгжүүлэн нийтдээ 57 нэр төрлийн бүтээгдэхүүн нийлүүлэхээр тус газрын дарга Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан болно.

Иргэний эрүүл мэндийн даатгалын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, даатгуулагчдад үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт хяналт тавих зорилтын хүрээнд.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаарх төрийн бодлого, Засгийн газар, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл, Эрүүл мэндийн яам, Газрын даргын болон бусад байгууллагуудын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг орон нутгийн албадад зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, төв орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулах, төсвийн тодотголд санал хүргүүлж батлуулах, төсвийн нарийвчилсан хуваарийг боловсруулах, гүйцэтгэлийг хангах, сангийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээнд шинжилгээ, судалгаа хийх, даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих мэндийн даатгалын гэрээг эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулах, гэрээний биелэлтэд хяналт тавьж, үнэлгээ өгөх, эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, тэдний өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.




Бүтэц, орон тооны талаар

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Эрүүл мэндийн даатгалын хяналт, санхүүжилтийн газрыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны “Нийгмийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн тухай” А/46 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газар болгон шинэчлэн зохион байгуулснаар Бодлого, төлөвлөлтийн, Санхүү бүртгэлийн, Тусламж, үйлчилгээний чанарын, Хяналт, шалгалтын гэсэн 4 хэлтэс, 34 орон тоотойгоор 2013 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлсэн.

Эрүүл мэндийн даатгалын газрыг шинэ бүтэц, орон тоогоор ажиллуулсан нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, , сэтгэл ханамжийг үнэлэх, даатгуулагчдыг мэдээллээр хангах, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих, харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх, төлбөр тооцоог түргэн шуурхай хийх нөхцлийг бүрдүүлсэн бүрдүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн үндсэн үзүүлэлтүүдийн талаар

2013 онд эрүүл мэндийн даатгалд 2864.5 мянган даатгуулагчийг хамруулан 185.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого бүрдүүлэн орлогын төлөвлөгөөг 101,0 хувиар биелүүлж, давхардсан тоогоор 3 843.2 мянган даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардалд 120.7 тэрбум төгрөгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.



Тус газар нь эрүүл мэндийн даатгалын сангийн орологын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, иргэд, даатгуулагчдыг даатгалд бүрэн хамруулж, эрүүл мэндээс үүсэх санхүүгийн эрсдэлээс хамгаалах, шаардлагатай үед тусламж, үйлчилгээг саадгүй авах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор иргэдийг эрүүл мэндийн даатгалд хамруулах ажлыг Боловсрол, шинжлэх ухааны яам /145,0 мян.оюутан/, Нийслэлийн боловсролын газар /Нийслэлийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуульд сурч буй 17-18 насны 16,3 мян.хүүхэд/, баг, хороодын Засаг дарга нар /100,0 мян. малчин/, Хөдөлмөрийн яам /191,5 мян.тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэн/, Гадаадын харьяатын асуудал эрхэлсэн газар /322 гадаадын иргэд/-тай тус тус хамтран ажилласны дүнд эрүүл мэндийн даатгалд 2864,5 мянган даатгуулагч буюу нийт хүн амын 97.7 хувь хамрагдсан нь урьд оноос 7.3 пунктээр нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын байгууллага нь төрийн өмчийн 102 эмнэлэг, хувийн хэвшлийн 136 эмнэлэг, 32 рашаан сувилал, 561 эмийн сантай эрүүл мэндийн даатгалын гэрээ байгуулан эдгээр эрүүл мэндийн байгууллагуудын 3843.2 мян. даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрт 120.7 тэрбум төгрөгийг олгосон байна.

Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар

Тус газар нь Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д хэлэлцүүлэхэд бэлтгэх Ажлын хэсэгт болон Засгийн газар, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөл, Нийгмийн даатгалын



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

ерөнхий газрын болон холбогдох бусад байгууллагуудын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар байгуулсан Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, ажил олгогч, даатгуулагчдын төлөөлөл, хамтрагч эрүүл мэндийн байгууллагууд, хувийн хэвшлүүдийн төлөөлөл бүхий Ажлын хэсгийн хүрээнд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрүүл мэндийн даатгалын шинэчлэл төсөл”-ийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратегийг боловсруулан Засгийн газрын 2013 оны 413 дугаар тогтоолоор батлуулсан.

Нийгмийн даатгалын байгууллагын эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны дунд хугацааны стратегийн төлөвлөгөө /2012-2016/-нд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор эрүүл мэндийн даатгалын чиг үүргийн хүний нөөцийн өнөөгийн байдалд хийсэн түргэвчилсэн үнэлгээнд үндэслэн “Эрүүл мэндийн даатгалын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр” /2013-2016 /-г боловсруулан НДЕГ-ын даргын 2013 А/251 тоот тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

Тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих талаар


Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилт, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг Архангай, Баян-Өлгий, Говьсүмбэр, Дундговь, Говь-Алтай, Өвөрхангай, Төв, Хөвсгөл, Дархан, Орхон, Дорнод, Дорноговь, Сүхбаатар зэрэг 13 аймгийн болон Багануур, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн даатгалын гэрээ бүхий 355 эрүүл мэндийн байгууллагуудын 2011, 2012 оны санхүүгийн баримтад шалгалт хийж 41 эрүүл мэндийн байгууллагад 8474 хүнд холбоотой 189,8 сая төгрөгийг төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоож, төлбөр зөрчлийг бүрэн барагдуулах арга хэмжээ авсан байна.

Санал дүгнэлт

Эрүүл мэндийн даатгалын газар нь одоогоор мөрдөгдөж буй хууль эрх зүйн хүрээнд сайн ажиллаж, нийт хүн амын 97,7 хувийг даатгалд хамруулж, даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. Мөн Эрүүл мэндийн

даатгалын газрыг шинэ бүтэц, орон тоогоор ажиллуулсан нь даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, сэтгэл ханамжийг үнэлэх, даатгуулагчдыг мэдээллээр хангах, даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих, харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтран ажиллах боломжийг сайжруулах, төлбөр тооцоог түргэн шуурхай хийх нөхцлийг бүрдүүлсэнээрээ чиг үүргийн хувьд дэвшил гарсан байна.

Мөн Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүжилтээр хийгдсэн “Эрүүл мэндийн нийгмийн даатгалын шинэчлэл” төслийн хүрээнд “Нийгмийн даатгалын байгууллагын эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны дунд хугацааны стратегийн төлөвлөгөө” /2012-2016 он/, “Эрүүл мэндийн даатгалын хөгжлийн урт хугацааны стратеги”/2013-2022 он/, Нийгмийн даатгалын байгууллагын даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах хөтөлбөр”/2012-2016/, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”/2013-2016/ зэрэг бодлогын бичиг баримтуудыг боловсруулан гаргасан нь эрүүл мэндийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоход үнэтэй хувь нэмэр оруулах ажлууд болсон байна.



Дээрх графикаас харахад сүүлийн 10 жилийн байдлаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 6,4 дахин өссөн байхад төрөөс 1 хүний эрүүл мэндийн даатгалд төлөх шимтгэлийн хэмжээ дөнгөж 34 хувиар өссөн байна. Мөн эрүүл мэндийн даатгалын сангаас олгож байгаа тусламж үйлчилгээний зардлын дээд хязгаар 1328,0 мянган төгрөг, төр дааж буй иргэдийн шимтгэл 670 төгрөгийн хооронд маш том зөрүү



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

харагдаж байна. Манай даатгалын тогтолцоо нь эв санааны зарчим дээр тулгуурлаж байгаа хэдий ч их хэмжээний зөрүү гарах нь тусламж үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж байна. Төрөөс эрүүл мэндийн даатгалд төлж байгаа энэ мөнгөөр өвчин намдаах эм авч хүрэхгүй хэмжээнд байна. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог нэвтрүүлсэн цагаас хойш тогтмол төлөх шимтгэлийн хэмжээг үнэ ханшны өсөлттэй уялдуулаагүйгээр барахгүй бараг нэмэгдүүлээгүй байгаа нь харагдаж байна. Иймд төр даадаг хүмүүсийн тоог цөөлөх, шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна. Тогтмол шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэн засгийн газраас тогтоодог цалингийн доод жишигтэй уялдуулах нь ЭМДС-ийн бие даасан тогтвортой үйл ажиллагааг хадгалах ач холбогдолтойгоос гадна даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч, сэтгэл ханамж дээшилэхэд чухал нөлөөтэй болно.

Эрүүл мэндийн даатгалын сангийн эмнэлгүүдээс ирүүлсэн нэхэмжлэлийг хянаж, даатгуулагчид үзүүлсэн эмчилгээ үйлчилгээний гүйцэтгэлийг хянадаг тогтолцоо нь хариуцлагын тогтолцоог бий болгох үндэс суурийг тавьсан. Гэвч Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь худалдан авагчийн хувьд бие даагаагүй, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээтэй уялдуулан гэрээ хийх эрх мэдэлгүй гэх мэт Эрүүл мэндийн даатгалын газрын үйл ажиллагаанаас хамаарахгүй олон гадаад хүчин зүйлийн улмаас Эрүүл мэндийн даатгалын сан худалдан авах ажиллагааг иж бүрнээр нь хэрэгжүүлж чадахгүй байна. Улсын эмнэлгүүд болон улс, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага хооронд зах зээлийн өрсөлдөөн бий болоогүй, даатгалын байгууллагын зүгээс өрсөлдөөнийг дэмжсэн бодлого явуулдаггүй байна.

Цаашид анхаарах асуудлууд:

-Эрүүл мэндийн даатгалын тухай хууль”/ шинэчилсэн найруулга/- ийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж батлуулах шаардлагатай талаар хүсэлт, танилцуулгыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх

-Эрүүл мэндийн даатгалын асуудлаар салбар хоорондын уялдаа холбоо, чиг үүргийн хуваарилалтыг тодорхой болгох талаар санал боловсруулж холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

-Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчлэн батлуулсаны дараа хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон өөрчлөгдөх эрх зүйн орчныг шинэчлэх ажлын бэлтгэлийг хангах

-Төрөөс дааж байгаа эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх талаар санал боловсруулж, холбогдох газруудад хүргүүлэх

Зургаа. Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эмнэлэг, хөдөлмөрийн магадлах чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх зорилтын хүрээнд:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэд эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс, аймаг, нийслэлийн дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн дэргэд орон нутгийн Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс ажиллаж байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь Монгол Улсын Засгын газрын 2008 оны 304 дүгээр тогтоолоор батлагдсан Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмийн 2.1-д тогтоож өгсний дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 102 тоот тушаалаар баталсан бүтцээр орон тооны 4, орон тооны бус 8 гишүүнтэйгээр аймаг, дүүргийн 32 комиссын орон тооны бус 328 гишүүдтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь орон нутгийн комиссыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, тэдгээрийн ажлыг шалган зааварлаж, эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаар гарсан маргаантай асуудлыг магадлан шийдвэрлэх ажиллаа.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах орон нутгийн комисс нь даатгуулагчдын ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацаа болон хөдөлмөрийн тусгай нөхцөл тогтоох асуудлыг магадлан шийдвэрлэж байна.

Нийт хөдөлмөрийн чадвар алдалтаар хувь тогтоолгогчдын тоо

Хүснэгт 1

№	Он	Хүний тоо	Бүгд	Өмнөх оноос өссөн
---	----	-----------	------	-------------------



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

		НДСангаас	НХСангаас		хувь
1	2009	57439	42075	99514	2.3
2	2010	56745	45015	101760	2.2
3	2011	56111	48055	104166	2.3
4	2012	55393	49452	104845	0.6
5	2013	55811	51863	107674	2.7

Нийгмийн даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэрт зарцуулсан хөрөнгө

Хүснэгт 2

№	Он	Хүний тоо	НДСангаас ТДТ авдаг ХБИ тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум төг/
1	2009	99514	57439	56,9
2	2010	101760	56745	59,3
3	2011	104166	56111	70,2
4	2012	104845	55393	111,8
5	2013	107674	55811	126,7

Нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэрт

зарцуулсан хөрөнгө

Хүснэгт 3

№	Он	Хүний тоо	НХСангаас ТДТ авдаг ХБИ тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум төг/
---	----	-----------	--------------------------------	------------------------------------



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

1	2009	99514	42075	18,6
2	2010	101760	45015	20,6
3	2011	104166	48055	26.0
4	2012	104845	49452	47.1
5	2013	107674	51863	58.1

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэрт зарцуулж буй хөрөнгө

Хүснэгт 4

№	Он	Хүний тоо	Зарцуулсан хөрөнгө /тэрбум төг/
1	2009	99514	75.6
2	2010	101760	79.9
3	2011	104166	96.2
4	2012	104845	158.8
5	2013	107674	184.8

Ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан болж буй өвчний хамгийн олон тохиолдож буй эхний 5 өвчин.

Хүснэгт 5

№	2012 он	2013 он
1	Сэтгэгцийн эмгэг – 20155 тохиолдолоор 19,2 хувь	Сэтгэгцийн эмгэг– 20298 тохиолдолоор 18.8 хувь
2	Мэдрэлийн өвчин 13944	Мэдрэлийн өвчин – 14104



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

	тохиолдолоор 13,3 хувь	тохиолдолоор 13.1 хувь
3	Ахуйн осол – 11503 тохиолдолоор 11,0 хувь	Ахуйн осол – 11630 тохиолдолоор 10.8 хувь
4	Цусны эргэлтийн системийн өвчин – 10032 тохиолдолоор 9,6 хувь	Цусны эргэлтийн системийн өвчин – 10286 тохиолдолоор 9.5 хувь
5	Нүдний өвчин – 9219 тохиолдолоор 8,8 хувь	Нүдний өвчин – 9666 тохиолдолоор 9,0 хувь

2013 онд дээрх аймаг, дүүргийн 28345 хүнийг дахин магадлалд хамруулсан нь нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн 23.0 хувийг хамарсан байна.

Санал дүгнэлт

2013 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тоо өмнөх оноос 2,7 хувиар буюу 2829 хүнээр өсч 107674 хүн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон байгаа бөгөөд үүний 5581 нь нийгмийн даатгалын сангаас, 51863 нь нийгмийн халамжийн сангаас тахир дутуугийн тэтгэвэр авдаг байна.

Сэтгэцийн эмгэг, мэдрэлийн өвчин, ахуйн осол, цусны эргэлтийн системийн өвчин, нүдний өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэд хамгийн олон тохиолдол буюу 18 бүлэг өвчнөөс энэ 5 бүлэг өвчлөл нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 61,2 хувийг эзэлж байна.

Нийгмийн даатгалын сан, нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа хүний тоо, зарцуулж буй хөрөнгийн хэмжээ жил дараалан өссөн байна. Жишээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэрт олгож байгаа хөрөнгийн хэмжээ сүүлийн 5 жилийн дотор 75,6 тэрбумаас 184,8 тэрбум болж даруй 2,4 дахин өссөн байна.

Тэтгэвэрийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан нэмэгдүүлсэн нь нэг талаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ядуурлаас хамгаалах, нийгмийн баталгаа хангах сайн талтай ч, нөгөө талаас харахад тэдний эдийн засгийн сонирхолыг нэмэгдүүлж, түүгээр амьдрах, бэлэнчлэх сэтгэлгээтэй хэсэг бүлгийг бий болгон, тэдгээр хүмүүсийг өвчнөө түргэн эмчлүүлж, эрүүлжин өөрийн мэргэжлийн болон таарч тохирох ажил хийх, амьдралаа сайжруулахын оронд амар



хялбараар мөнгө авч, амьдралаа залгуулах сонирхолыг нэмэгдүүлж, нийгмийн идэвхигүй бүлгийг бий болгож байна.

Цаашид анхаарах асуудлууд:

-Улсын хэмжээн тахир дутуугийн ангилал зэрэглэл тогтоох мэргэжлийн лаборатори байгуулах,

-Тахир дутуугийн ангилал зэрэглэлийг тогтоох нормативийг олон улсын жишигт нийцсэн байдлаар хийж, мөрдүүлэх,

-Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын бүтцийг боловсронгуй болгож, нарийн мэргэжил / дотор, мэдрэл, мэс засал, гэмтэл, чих хамар хоолой, сэтгэц, нүд /-ийн магадлагч эмч нарыг орон тоогоор ажиллуулах, эмч мэргэжилтнүүдийг сургаж мэргэшүүлэх ,гадаад сургалтанд хамруулж, туршлага судлуулах ажлыг зохион байгуулах

-Дотор эрхтний өвчнүүд болон зарим нэгэн осол гэмтлийн улмаас хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн /хагас 50-69 хувь/ түр болон удаан хугацаагаар алдсан иргэдэд тахир дутуугийн тэтгэвэр олгохгүйгээр тодорхой зөвлөмж аргачлалын дагуу эм олгох, рашаан сувилалд үнэ төлбөргүйгээр сувилуулах, эмчлэх, нөхөн сэргээх эмчилгээг хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаанд үнэ төлбөргүй хийх , хоёр, гуравдагч шатны эмнэлэгт эмчлүүлэхэд Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах, хөнгөлөлт үзүүлэх хэлбэрээр шийдвэрлэх боломжуудыг судалж ,хэрэгжүүлэх

-Хөгжлийн бэрхшээлтэй ,хөдөлмөрийн чадвараа хагас алдсан иргэнд тахир дутуугийн тэтгэвэр олгож ,нийгмийн идэвхигүй бүлэг болгохгүйгээр нийгмийн бүхий л түвшинд тэдний оролцоог нэмэгдүүлэх, тэдний амьдрах, боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчинг бүрдүүлэх

-Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх нийгмийн арга хэмжээг нэмэгдүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэнд, сэтгэл зүй, оюун санааны нөхөн сэргээлтийн үйлчилгээг сайжруулах, нийгэм хамт олонд тулгуурласан нөхөн сэргээлтийг хэрэгжүүлэх.

-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих.



-“Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм” болон хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход баримтлах өвчний жагсаалтыг шинэчилж, боловсронгуй болгох

-Сэтгэцийн эмгэг, мэдрэлийн өвчин, ахуйн осол, цусны эргэлтийн системийн өвчин, нүдний өвнүүд хөдөлмөрийн чадвар алдалтын зонхилох шалтгаан болж байгааг анхааралдаа авч, судалгаа хийж үр дүнг холбогдох байгууллага албан тушаалтанд танилцуулж, арга хэмжээ авах

Долоо. Хууль тогтоомжийн хэрэгжилт, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, дүгнэлт гаргаж үйл ажиллагаа, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах зорилтын хүрээнд:

Хяналт шалгалтын ажлын талаар

2013 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нийт 14 аймаг, 58 сум /Дорноговь, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Говьсүмбэр, Баян-Өлгий, Архангай, Хөвсгөл, Төв, Дархан-Уул, Орхон, Дорнод, Сүхбаатар, Булган, /2 дүүрэг/ Сонгинохайрхан, Баянзүрх/-ийн нийгмийн даатгалын хэлтсийг хамруулан нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагааны зардлын зарцуулалтанд хяналт шалгалтыг хийсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтсүүдэд хийсэн шалгалтаар 13,9 мянган ажил олгогч, 263,3 мянган даатгуулагчийг хамруулан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан тооцооны үндэслэл, 15,3 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийн тогтоолт, 122,5 мянган тэтгэвэр авагчийн хувийн хэргийн баримтын бүрдүүлэлт, олголтыг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрд нь засаж залруулан, илүү болон дутуу олгосон тэтгэврийн 183,6 сая төгрөг, 18,0 мянган даатгуулагчийн тэтгэмжийн бодолт, олголтыг шалгаж, илүү олгосон тэтгэмжийн 17,7 сая төгрөг, нийт 201,3 сая төгрөгийг улсын байцаагчийн акт тогтоож, төлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 66 аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын хөлс, ажилтнуудад олгосон түлээ нүүрсний үнийн хөнгөлөлт зэрэг шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнийг дутуу тооцож, зөрчил гаргасан 37 ажил олгогчид 83,0



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

сая төгрөгийн шимтгэл, алдангийг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Нийслэлийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 87, барилгын угсралт болон засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 78, нийт 165 байгууллагад шалгалт хийж, 93 ажил олгогчийн шимтгэл ногдуулаагүй 3899,6 сая төгрөгийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод 644,2 сая төгрөгийн шимтгэл нөхөн ногдуулж, 320,8 сая төгрөгийн алданги тооцож, нийт 965,0 сая төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэснээс 959,9 сая төгрөг буюу 99.5 хувийг барагдуулсан байна.

Хяналт, шинжилгээ үнэлгээний газар нь тайлант хугацаанд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд төлөвлөгөөт шалгалтыг хуваарийн дагуу явуулж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр нь таслан зогсоож, цаашид дахин давтан гаргуулахгүй байх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг даалгавар өгч, биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан байна.

Мөн шалгалтын хугацаанд тухайн аймгийн сумдын байцаагч нарт /нийт 156 сумын байцаагч хамрагдсан/ зориулан сургалт зохион байгуулж, хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, тулгамдсан асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар мэргэжлийн зөвөлгөө өгсөн байна.

2013 онд нийгмийн даатгалын нэгдсэн өгөгдлийн сангийн мэдээлэлд тулгуурлан ажилгүйдлийн даатгалын сангийн 2011 оны зарлагаас 14 аймгийг хамруулан 6757 даатгуулагчид олгосон ажилгүйдлийн тэтгэмжийн бодолт олголтыг шалгаж, сайн дурын даатгалд иргэдийг нөхөн даатгаж, тэтгэмж авах эрх үүсгэсэн, ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа ажилд орсон байхад тэтгэмжийг үргэлжлүүлэн олгосон, тэтгэмж олгох хувийг буруу тооцсон, дундаж цалинг буруу тооцож, тэтгэмж илүү олгосон зэрэг 119 хүнд холбогдох зөрчлийг илрүүлж, 86 хүнд илүү олгосон 42,3 сая төгрөгийг буцаан төлүүлэхээр шийдвэрлэж, 9 хүнтэй холбоотой 3,2 сая төгрөгийг Халамж үйлчилгээний хэлтсээс буцааж, санд татах ажлуудыг хийсэн байна.

Тэтгэмжийн даатгалын сангийн 2011 оны зарлагын тооцооллыг 21 аймаг, 9 дүүргийн хэлтэст шалгаж, хугацаа хожимдуулсан, тэтгэмжийн хувь буруу тооцсон 679



хүний жагсаалтыг дахин нягтлан шалгуулахаар хэлтсүүдэд хүргүүлснээс 57 хүнтэй холбоотой 9,4 сая төгрөгийн төлбөрийг төлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Санал дүгнэлт

Хяналт шалгалтын ажлын тайлангаас харахад нийгмийн даатгалын багц хуулиудыг зөрчсөн үйлдлүүд түүний дотор тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас, нас барсан хүний тэтгэврийг авах болон ажилгүйдлийн тэтгэмж, жирэмсэн амаржсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжийг давхардуулан авсан зөрчлүүд нэлээд илэрсэн байна. Эдгээр зөрчлүүд нь хуулийн хэрэгжилт хангалтгүйгээс гадна мэдээлэлийн солилцоо муу, хяналт шалгалтын явцад хийгдэх техник ажлууд их байдгаас цаг хугацааны хувьд хүрэлцэхгүй шалтгаанаар хууль зөрчсөн үйлдлүүдийг дутуу илрүүлдэг, үүнээс болж санаатай болон санамсаргүй байдлаар дээр дурдсан үйлдлүүд давтагдаж, олон удаа гарах нөхцлийг бүрдүүлсэн байна. Зөрчил олон удаа гарсанаараа нийгмийн даатгалын санд хохирол учруулах эрсдлийг нэмэгдүүлж байна.

Мөн дээрх үйлдлүүдэд байцаагчийн санаатай болон санамсар болгоомжгүй үйлдлээс болсон уу гэдгийг тогтоож, байцаагчид тооцох хариуцлагын механизмыг бий болгох шаардлагатай байна.

Цаашид анхаарах асуудлууд:

-Хяналт шалгалтыг хийхэд мэдээлэлийн баазтай цахимаар холбогдох боломжийг бүрдүүлэх, дээр дурдсан давхардлуудыг хянах программ хангамжийг хийж ашиглах, мэдээлэлийг богино хугацаанд авах боломжийг бүрдүүлэх

-Улсын байцаагчийн ур чадварыг нэмэгдүүлэх, санаатай болон санамсаргүй үйлдлээс болж алдаа гаргасан, санд хохирол учруулсан тохиолдолд хариуцлага тооцдог болох

-Байцаагчид хэрхэн хариуцлага тооцох талаар судалж, дүгнэлт санал боловсруулах

Найм. Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээлэлийн сан бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт,



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

гадаад дотоод мэдээлэлийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх зорилтын хүрээнд:

Программ хангамжийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтийг хангуулах чиглэлээр

“Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр дараах 4 программ хангамжийг шинээр нэвтрүүлсэн байна. Үүнд:

Ажилласан жилээ нөхөн тооцуулах хүсэлт гаргасан иргэдийн мэдээллийг бүртгэх, ажилласан жил тасарсан хугацааг тооцох, үүнтэй уялдуулан төлөх шимтгэлийн тооцоог хийх вэб программ хангамжийг 21 аймаг 9 дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс, 7 тасагт нэвтрүүлж, уг програм хангамжаар хуульд хамрагдсан нийт 496.7 мянган иргэд даатгуулагчийн мэдээлэл бүртгэж, НДЕГ-т хянан баталгаажуулах боломжийг бүрдүүлж, 32,5 тэрбум төгрөгийн нөхөн шимтгэлийн орлого бүртгэгдэх ажлын программаар гүйцэтгэсэн байна .

Үндэсний Аудитын газрын зөвлөмжийг нэгжүүдэд хангуулах чиглэлээр Нийгмийн даатгалын сангийн нэгдсэн тайланг Сангийн яамны албан ёсны зөвшөөрөл бүхий Plastic программ хангамжид хөрвүүлэн гаргах боломжийг бүрдүүлэх зорилгоор дараах 2 программ хангамжийг нэгжүүдэд шинээр нэвтрүүлсэн .

Салбарын нэгдсэн сүлжээг өргөтгөх, засвар үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх чиглэлээр

Нийгмийн даатгалын салбарын 21 аймаг, 9 дүүрэг, НДЕГ-ыг холбосон нэгдсэн сүлжээнд Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Дорноговь аймгийн Замын-Үүд, Сэлэнгэ аймгийн Хөтөл, Мандал, Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нийгмийн даатгалын тасгуудтай интернэтээр холбогдон, онлайнаар мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн байна.

Салбарын хэмжээнд үүсгэн ажиллаж буй нэгдсэн мэдээллийн санг ашиглах хүрээг өргөжүүлэх чиглэлээр

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ашиглагдаж буй мэдээллийн санг баяжуулах, төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудтай уялдаа холбоог сайжруулах зорилгоор УБЕГ-тай мэдээлэл солилцох, НХҮЕГ-аас халамжийн тэтгэвэр авагчдын мэдээлэлийг авч, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчидтай тулгаж,



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

давхардлыг арилгах, Үндэсний дата төвийн мэдээлэлийн санд 1,0 гаруй тэтгэвэр авагчийн нэрийн дансны мэдээлэлийг байршуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын мэдээллийг цахимаар хүргэх зорилт тавьж, иргэдийн и-мэйл хаяг, утасны дугаарыг бүртгэх вэб програм хангамж ашиглан нийт давхардсан тоогоор 103,9 мянган даатгуулагчийн утасны дугаар, имэйл хаягийн мэдээллийн санг бүрдүүлж, нэгдсэн мэдээллийн санд тулгуурлан даатгуулагчдын 2006 оноос хойшхи шимтгэл төлөлтийн мэдээллийг цахимаар өгөх мэдээллийн санг бэлтгэж, энэ тухай 50.0 мянга гаруй даатгуулагчид имэйлээр зар хүргэсэн нь цахим үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр хийсэн шинэлэг ажил болсон байна.

Нэгдсэн мэдээллийн санг ашиглан судалгаа тооцоо хийх чиглэлээр

Төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох зорилгоор болон бусад төрийн, төрийн бус байгууллагуудын хүсэлтээр нийт 100 гаруй судалгаа тооцоог нэгдсэн мэдээллийн сан ашиглан гаргасан байна.

Нэгдсэн сүлжээний талаар

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 21 аймаг алслагдсан 3 дүүрэг 512 kbps, хотын төвийн 6 дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс 8Mbps хурдны шилэн кабелиар НДЕГ-тай холбогдон нэгдсэн сүлжээ үүсгэж иргэд, даатгуулагч, ажил олгогчдын шимтгэл төлөлт, тэтгэвэр тэтгэмж, зардал авалтын мэдээллийг өдөр тутам татан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, нийгмийн даатгалын үйлчилгээ болон мэдээ тайлан, судалгаа тооцоо, лавлагааг гаргаж байна. Нийгмийн даатгалын тасгууд /10 сум/-ын хувьд интернэтээр нэгдсэн сүлжээнд холбогдож байгаа тул үүсгэж буй мэдээллийн сан бусад мэдээллийг хамгийн багадаа 1 хоногийн хоцрогдолтой дамжуулж байгаа ба бусад сумдын хувьд нэгдсэн сүлжээнд холбогдоогүй тул мэдээллийн урсгал үүнээс урт хугацаагаар хоцрогдолтой байна.

Техник хангамжийн чиглэлээр

Түүнчлэн салбарын хэмжээнд 50 гаруй сервер компьютер, 1000 орчим ажлын компьютер 40 компьютерийн локал сүлжээнд холбогдон ажиллаж байна.

Нийт сумдыг ажлын компьютер, хэвлэгчээр хангах, интернэт болон нэгдсэн сүлжээнд холбогдох ажил хийгдээгүй байна.



Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр НДЕГазар, 21 аймаг, хотын төвийн 6 дүүрэгт дэвшилтэт технологийн рутер суурилуулсан ба алслагдсан 3 дүүрэг, нийгмийн даатгалын тасгуудад суурилуулах шаардлагатай.

Програм хангамж, мэдээллийн сангийн чиглэлээр

Салбарын хэмжээнд нягтлан бодох бүртгэл, бусад үйл ажиллагааг автоматжуулсан 40-өөд програм хангамж ашиглагдаж байгаагаас 10 гаруй нь нийгмийн даатгалын онцлогт нийцүүлэн нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн хөтлөх, тайлан баланс гаргах, нэгтгэх боломж бүхий багц програм хангамж бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хэрэглэгдэж байна.

Мөн сүүлийн жилүүдэд дотоод болон гадаад хэрэглэгчдэд зориулж вэбд суурилсан 10 гаруй программ хангамж шинээр нэвтрүүлсэн.

Харин лицензтэй програм хангамж худалдан авахад өндөр зардал шаардагдах тул сервер болон ажлын компьютеруудын үйлдлийн систем, өгөгдлийн сангийн удирдлагын систем ашиглалтын лицензгүй байна.

Одоогийн байгаа техникийн хүчин чадлын хэмжээнд нийгмийн даатгалын салбарын сүүлийн 10 гаруй жилийн мэдээллийг багтаасан 900Gb орчим мэдээлэлтэй нэгдсэн мэдээллийн санг ашиглан төрийн байгууллагууд, ажил олгогч, даатгуулагчдад мэдээлэл лавлага өгөх, тооцоолол хийх ажлуудыг хийж байна.

Санал дүгнэлт

Нийгмийн даатгалын үйл ажиллагааны хамрах хүрээ өргөжиж, даатгуулагч, ажил олгогч сайн дурын даатгуулагчдын тоо өссөн, нийгмийн даатгалын байгууллагаас төрийн болон төрийн бус байгуулагудын авах лавлагаа, тодорхойлолтын эрэлт өссөн, салбарын ажилтнуудын ажлын ачаалал эрс нэмэгдсэн, мэдээллийн бааз хангалтгүйгээс тэтгэвэр тэтгэмжийг давхардуулан олгосон зөрчлүүд гарсан зэрэг шалтгаануудын улмаас нийгмийн даатгалын байгууллагад мэдээллийн технологийн иж бүрэн шинэчлэлийг яаралтай хийх шаардлагатай байна. Сумдуудыг интернетэд холбож тайлан мэдээг цахимаар илгээх, сумдын мэдээллийн санг нэгдсэн сүлжээнд холбох, аймаг, нийслэлийн хэлтсийн үйлчилгээний танхимд дараалалын систем нэвтрүүлэх, лавлагаа тодорхойлолтуудыг гаргах автомат машин суурилуулах, сүлжээний хурдыг нэмэгдүүлэх зэрэг ажлуудыг нэн даруй эхлүүлэх нь зүйтэй. Дээрх асуудлуудыг



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

шийдсэнээрээ нийгмийн даатгалын үйлчилгээг иргэддээ чирэгдэлгүй, шуурхай хүргэх, салбарын ажилтнуудын ажлын ачаалалыг багасгах, даатгалын сангуудад хохирол учрах эрсдлийг бууруулж, зайнаас хяналт хийх нөхцөл бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

Мэдээлэлийн технологийн шинэчлэл хийх төслийг хийж, холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, холбогдон гарах санхүүгийн эх үүсвэрийг улсын төсөвт суулгах болон гадаад дотоодын төсөл хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх боломжуудыг судлан, зохих шийдвэр гаргуулах

Нэгдсэн дүгнэлт, санал

Нийгмийн даатгалын байгууллагууд нь 2013 онд үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, стратегийн зорилтуудын хүрээнд төлөвлөсөн ажлуудаа амжилттай биелүүлж, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө 97,8 хувиар, нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийг 104,8 хувиар биелүүлж, санд 1018,1 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Сангийн хөрөнгө өмнөх оноос 30,1 хувиар өсөж, 939,9 тэрбум болсон, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллага 35,4 мянга болж, өмнөх оноос 16,3 хувь буюу 4,9 мянгаар, сайн дурын даатгуулагч 46,9 мянгаар нэмэгдсэн, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 820,0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 406,1 тэрбум төгрөгөөр буюу 98,1 хувиар нэмэгдэж, санхүүгийн чадвар эрс дээшилсэн зэрэг олон үзүүлэлтийг өсгөж чадсанаараа өмнөх жилүүдтэй харьцуулахад үсрэнгүй амжилттай ажилласан байна.

Тайлант онд “Ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийг амжилттай хэрэгжүүлж чадсан нь дээрх үзүүлэлтүүд өсөхөд голлох нөлөө үзүүлсэн. Мөн нөгөө талд нь нийгмийн даатгалын салбарын мэргэшсэн, чадварлаг багийн хамт олны хөдөлмөр зүтгэлийн үр дүнд дээрх амжилтууд гарсан байна.

Тайлант хугацаанд НДЕГ нь хууль эрх зүйн орчноо боловсронгуй болгох, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөтгөх, даатгалын цар хүрээг өргөтгөх, даатгуулагчдыг мэдээлэлээр хангах, даатгалын ач тусыг иргэдэд ойлгуулах,



даатгуулагчдад чирэгдэлгүй хөнгөн шуурхай үйлчлэх чиглэлээр олон шинэлэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Цаашид өнөөгийн хүрсэн амжилтдаа тайвшралгүй, даатгалын тогтолцоогоо боловсронгуй болгох, эрх зүйн шинэчлэл хийх, даатгалын сангуудын бие даасан, тогтвортой үйл ажиллагааг хангах талаар анхаарч, шуурхай арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй.

Тухайлбал: Тэтгэвэр авагчдын тооны өсөлт, мөн хүн амын дундаж наслалт өссөнтэй холбоотойгоор ирээдүйд тэтгэврийн даатгалын сангаас гарах зардлын хэмжээ өссөнөөр тэтгэврийн даатгалын сан хүрэлцэхгүй болох, Эрүүл мэндийн даатгалын шимтгэлд төрөөс төлж байгаа мөнгөний хэмжээ нь зах зээлийн үнэ ханшны өсөлттэй уялдаагүй хэт бага, шимтгэлийг нь төр даах иргэдийн тоо олон байгаа нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт нөлөөлөх гэх мэт асуудалд судалгаа, прогноз хийж, шийдэх гарцуудыг хайж, арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй.

Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хууль/шинэчилсэн найруулга/-ийг нэн даруй батлуулах шаардлагатай байна.

Мөн салбарын мэдээлэлийн технологийн иж бүрэн шинэчлэлийг хийх асуудлыг яаралтай шийдэх шаардлагатай байна.

Мэдээлэлийн технологийн шинэчлэлийг хийх нь зөвхөн салбарын эрх ашигт бус мянга мянган даатгуулагчдын цаг завьг хэмнэсэн, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, хөнгөн шуурхай хүргэхэд ихээхэн хувь нэмэр оруулах ажил болох юм.

Сүүлийн жилүүдэд даатгуулагч, ажил олгогчдын 2 дахин өссөн байхад салбарт ажиллагсдын тоо бараг нэмэгдээгүй байна.

Ялангуяа нийслэлийн хүн ам ихтэй дүүргүүдэд нэг байцаагчид 5,0-8,0 мянган үйлчлүүлэгч оногдож байгаа нь байцаагчид ажлын ачааллаа дийлэхгүй болох мөн нөгөө талд нь дараалал үүсэх, иргэдийг олон дахин явуулах зэрэг хүндрэлүүд үүсгэж байна. Иймд салбарын ажилтнуудын орон тоог нэмэгдүүлэх асуудлыг яаралтай шийдүүлэх шаардлагатай байна.



Ажлын хэсэг



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

